БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БНА-2021/44/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2021 он


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг:Tseenyama@audit.gov.mn

Аудитор: Б.Нарангэрэл

Утас: 99009293 Цахим хаяг:Narangerelb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга


1.Аудитын гэрчилгээ /эх хувь/ ........ 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ 12

3.Аудитын тайлан ........ 13

3.1. Ерөнхий зүйл ........ 13

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ........ 13

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ........ 13

3.4. Материаллаг байдал ........ 14

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 14

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ........ 15

3.7. Шилэн дансны мэдээлэл ........ 17

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 17

3.9. Аудитын илрүүлэлт ........ 18

Залруулсан алдаа ........ 18

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ........ 18

Аудитын зөвлөмж ........ 18

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ........ 18

4. Менежментийн захидал ........ 18

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ........ 20




005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021. 02.04 № 2/14

танай ____________ -ны № ____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
Ц.ИДЭРМӨНХ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын



005 00502086I
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **34,489,629.38** | **41,447,929.38** |
| **33** | **АВЛАГА** | 17,750.38 | 57,465.38 |
| **335** | **Бусад авлага** | 17,750.38 | 57,465.38 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 17,750.38 | 57,465.38 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 34,471,879.00 | 41,390,464.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 34,471,879.00 | 41,390,464.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 385,479.00 | 402,239.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,086,400.00 | 10,667,425.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 320,800.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,526,174,786.37** | **9,589,870,046.72** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 10,526,174,786.37 | 9,589,870,046.72 |
| **392** | **Биет хөрөнгө** | 10,526,174,786.37 | 9,589,870,046.72 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 11,101,428,252.71 | 11,126,427,951.21 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -834,764,648.52 | -1,670,026,401.04 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 803,612,390.06 | 803,612,390.06 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -610,588,103.20 | -743,412,390.14 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 30,762,571.60 | 38,131,400.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -23,293,160.76 | -24,967,085.95 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 15,229,270.00 | 20,807,770.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8,188,075.07 | -9,622,810.01 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 61,321,341.50 | 61,321,341.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -9,663,351.95 | -12,720,418.91 |
| 39217 | Ном | 318,300.00 | 318,300.00 |
| 39301 | Программ хангамж | 450,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **10,560,664,415.75** | **9,631,317,976.10** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **10,560,664,415.75** | **9,631,317,976.09** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 10,560,664,415.75 | 9,631,317,976.09 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 5,460,740,325.27 | 4,531,393,885.61 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 5,460,740,325.27 | 5,460,740,325.27 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -929,346,439.66 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 5,099,924,090.48 | 5,099,924,090.48 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **10,560,664,415.75** | **9,631,317,976.09** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **334.396.182.00** | **306,524,924.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **183.864.382.00** | **128,479,824.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 183.864.382.00 | 128,479,824.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 183.864.382.00 | 128,479,824.50 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 91.064.382.00 | 78,953,401.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 92.800.000.00 | 49,526,423.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **150.531.800.00** | **178,045,100.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 5,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 150.531.800.00 | 173,045,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 150.531.800.00 | 173,045,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1.203.950.488.37** | **1,227,840,564.16** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1.203.950.488.37** | **1,227,840,564.16** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1.134.247.269.27 | 1,159,666,434.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 111.578.816.59 | 128,741,017.07 |
| 210101 | Үндсэн цалин | 111.578.816.59 | 100,615,679.53 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 21,342,337.54 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 6,783,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 14.273.546.43 | 16,583,039.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9.764.359.61 | 11,920,885.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1.154.449.39 | 1,239,657.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 901.317.31 | 944,685.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 221.881.35 | 228,866.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2.231.538.77 | 2,248,944.70 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11.208.369.50 | 12,858,134.89 |
| 210401 | Бичиг хэрэг | 4.170.520.00 | 4,521,140.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5.411.050.00 | 5,581,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1.276.299.50 | 1,425,494.89 |
| 210404 | Ном, хэвлэл | 350.500.00 | 322,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 1,008,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 3.158.400.00 | 3,500,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 3.158.400.00 | 3,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5.181.000.00 | 3,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5.181.000.00 | 3,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7.811.800.00 | 2,000,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 7.811.800.00 | 2,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15.035.450.00 | 14,613,405.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14.541.140.00 | 14,089,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 250,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 152.810.00 | 121,005.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 141.500.00 | 141,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 00.00 | 11,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 965.999.886.75 | 978,370,838.15 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 1,340,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1.000.000.00 | 1,000,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 964.999.886.75 | 976,030,838.15 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 69.703.219.10 | 68,174,129.96 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 600.000.00 | 1,433,836.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600.000.00 | 1,433,836.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 68.589.822.00 | 65,593,401.00 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 00.00 |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | 00.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 68.589.822.00 | 65,593,401.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 513.397.10 | 1,146,892.96 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 513.397.10 | 1,146,892.96 |
| 213404 | Хөрөнгийн | 00.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(869.554.306.37)** | **-921,315,639.66** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 8,030,800.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 8,030,800.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -8,030,800.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(869.554.306.37)** | **-929,346,439.66** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **241,596,182.00** | **256,998,501.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **91,064,382.00** | **78,953,401.00** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 91,064,382.00 | 78,953,401.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 91,064,382.00 | 78,953,401.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 91,064,382.00 | 78,953,401.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **150,531,800.00** | **178,045,100.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 5,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 150,531,800.00 | 173,045,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 150,531,800.00 | 173,045,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **241,596,182.00** | **251,458,501.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **241,596,182.00** | **251,458,501.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **170,992,962.90** | **183,284,371.04** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 111,078,813.40 | 128,818,979.96 |
| 210101 | Үндсэн цалин | 86,542,513.40 | 94,918,442.42 |
| 210102 | Нэмэгдэл | 16,550,300.00 | 25,665,537.54 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,986,000.00 | 8,235,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 13,891,300.00 | 16,544,791.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,439,878.74 | 11,422,698.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,201,813.29 | 1,313,479.03 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 804,706.33 | 1,033,983.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 222,301.06 | 252,239.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,222,600.58 | 2,522,391.08 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,526,099.50 | 12,350,194.89 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,203,800.00 | 4,674,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,531,800.00 | 5,901,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,439,999.50 | 1,433,894.89 |
| 210404 | Ном, хэвлэл | 350,500.00 | 340,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,722,100.00 | 3,000,000.00 |
| 210602 | Тавилга | 5,676,100.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,046,000.00 | 3,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,811,800.00 | 2,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,811,800.00 | 2,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,462,850.00 | 14,730,405.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,968,540.00 | 14,206,900.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 250,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 152,810.00 | 121,005.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 141,500.00 | 141,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 00.00 | 11,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,000,000.00 | 2,340,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 1,340,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **70,603,219.10** | **68,174,129.96** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,500,000.00 | 1,433,836.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 1,433,836.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 68,589,822.00 | 65,593,401.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 68,589,822.00 | 65,593,401.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 513,397.10 | 1,146,892.96 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 513,397.10 | 1,146,892.96 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **5,540,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **5,540,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **5,540,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 5,540,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 5,540,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-5,540,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 5,099,924,090.48 | 6,330,294,631.64 | 00.00 | 11,430,218,722.12 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **5,099,924,090.48** | **6,330,294,631.64** | **00.00** | 11,430,218,722.12 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -218,314,152.12 | 00.00 | -218,314,152.12 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **5,099,924,090.48** | **5,460,740,325.27** | **00.00** | 10,560,664,415.75 |
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **5,099,924,090.48** | **5,460,740,325.27** | **00.00** | 10,560,664,415.75 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **5,099,924,090.48** | **5,460,740,325.27** | **00.00** | 10,560,664,415.75 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -929,346,439.66 | 00.00 | -929,346,439.66 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **5,099,924,090.48** | **4,531,393,885.61** | **00.00** | 9,631,317,976.09 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 186,045,100.00 | 185,258,207.04 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 186,045,100.00 | 185,258,207.04 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 184,545,100.00 | 183,824,371.04 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 128,819,000.00 | 128,818,979.96 |
| 210101 | Үндсэн цалин | 94,167,800.00 | 94,918,442.42 |
| 210102 | Нэмэгдэл | 25,939,200.00 | 25,665,537.54 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,712,000.00 | 8,235,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,252,400.00 | 16,544,791.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,051,600.00 | 11,422,698.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,300,200.00 | 1,313,479.03 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,040,200.00 | 1,033,983.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 260,000.00 | 252,239.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,600,400.00 | 2,522,391.08 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,896,300.00 | 12,890,194.89 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,214,500.00 | 5,214,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,901,800.00 | 5,901,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,440,000.00 | 1,433,894.89 |
| 210404 | Ном, хэвлэл | 340,000.00 | 340,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,500,000.00 | 3,500,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,000,000.00 | 8,000,000.00 |
| 210602 | Тавилга | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,737,400.00 | 9,730,405.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,206,900.00 | 9,206,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 250,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 128,000.00 | 121,005.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 141,500.00 | 141,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 11,000.00 | 11,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2340000.00 | 2340000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,340,000.00 | 1,340,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1500000.00 | 1433836.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,500,000.00 | 1,433,836.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 1,433,836.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 186,045,100.00 | 185,258,207.04 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 173,045,100.00 | 173,045,100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 173,045,100.00 | 173,045,100.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 13,360,000.00 | 13,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,360,000.00 | 13,000,000.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 10.00 | 10.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 07.00 | 07.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 02.00 | 02.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **09.00** | **09.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 07.00 | 07.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 02.00 | 02.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **5,000,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **5,000,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 5,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 5,000,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 5,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 5,000,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 5,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 5,000,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч Ц.Идэрмөнх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 02-аас 2021 оны 02 дугаар сарын 04–ний хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 сарын 22-ний өдрийн А/265 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Орон нутгийн өмч хөрөнгийг хамгаалах, шилжүүлэх, актлах зэрэг харилцааг зохицуулах мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 45.5 болон 48.3-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн захиалгыг үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах эрх олгох үйл ажиллагааг энэхүү хууль, журмын хүрээнд зохион байгуулах чиг үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн алба санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд 2020 оны эхний хагас жилийг хамруулан шалгалт хийсэн бөгөөд уг шалгалтаар Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн алба нь илгээвэл зохих 38 мэдээллийг бүрэн мэдээлсэн гэж тайлагнасан ч дахин шалгахад 77549.6 мянган төгрөгийн 8 мэдээллийг цахим хуудаст мэдээлээгүй байна.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн төвшнийг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын төвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 921678.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 9216.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон, гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1235871.4 мянган төгрөгийн 1 хувь буюу 12358.7 сая төгрөгөөр тооцсон.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 9,631,318.0 мянган төгрөг болж өмнөх оноос 936,346.4 мянган төгрөгөөр буюу 9.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт / мянган төгрөг /

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 34,489.6 | 41,447.9 | 6,958.3 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 17.8 | 57.5 | 39.7 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 34,471.9 | 41,390.5 | 6,918.6 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 10,526,174.8 | 9,589,870.0 | (936,304.7) |
| Үндсэн хөрөнгө | 12,013,122.1 | 12,051,069.2 | 37,947.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,486,947.3) | (2,461,199.1) | (974,251.8) |
| **Нийт хөрөнгө** | 10,560,664.4 | 9,631,318.0 | (929,346.4) |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 10,560,664.4 | 9,631,318.0 | (929,346.4) |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 10,560,664.4 | 9,631,318.0 | (929,346.4) |

Бараа материалын дансны үлдэгдэл 41,390.5 мянган төгрөг болж 6,918.6 мянган төгрөгөөр өссөн нь Баянхонгор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн 89 дугаар тогтоолоор "Баянхонгор хайрхан фарм" ОНӨААТҮГ-аас балансаас баланст шилжүүлсэн аж ахуйн материалыг орлогод авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 12,051,069.2 мянган төгрөг болж 37,947.0 мянган төгрөгөөр өссөн нь Баянхонгор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020.07.31-ны өдрийн 48 дугаар тогтоолоор 4 нэр төрлийн 24999.7 мянган төгрөгийн барилга байгууламж, Баянхонгор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн 89 дугаар тогтоолоор "Баянхонгор хайрхан фарм" ОНӨААТҮГ-балансаас баланст шилжүүлсэн 17044.2 мянган төгрөгийн хөрөнгүүдийг орлого авсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,631,318.0 мянган төгрөг болж 929,346.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн зардлаас шалтгаалжээ.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн албаны 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 306524.9 мянган төгрөг болж өмнөх оноос 27871.3 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар буурсан нь өмнөх онд үнэ төлбөргүй авсан орлого 92800.0 мянган төгрөг байснаас тайлант онд 43273,6 мянган төгрөгөөр буурсан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Нийт зардал 1,227,840.6 мянган төгрөг болж өмнөх оноос 23890.0 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нэмэгдсэн, бараа үйлчилгээний урсгал зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 223871.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 223871.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 36426,5 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Төсвийн төслөөр хангамж, бараа материалын зардлыг 11186.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засврын зардлыг 13680.0 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 8150.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 186045.1 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

төсвөөс 173045.1 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоор 13000.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 173045.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор 13360.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 185258.2 мянган төгрөгийг зарцуулж, нийт 1146.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 185258.2 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 707.6 мянга, хангамж бараа материалын зардлыг 6.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 6.9 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 66.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт2: Төсөв зардлыг эдийн засгийн ангиллаар харуулбал:

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| Хөтөлбөр 70426 | | | | | |
| Арга хэмжээ 80101 | | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 186,045,100.00 | 185,258,207.04 | 786,893.0 | 99.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 186,045,100.00 | 185,258,207.04 | 786,893.0 | 99.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 184,545,100.00 | 183,824,371.04 | 720,729.0 | 99.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 128,819,000.00 | 128,818,979.96 | 20.0 | 100.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 17,252,400.00 | 16,544,791.19 | 707,608.8 | 95.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 00.00 | 00.00 | 0.0 | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 12,896,300.00 | 12,890,194.89 | 6,105.1 | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 3,500,000.00 | 3,500,000.00 | 0.0 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,000,000.00 | 8,000,000.00 | 0.0 | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.0 | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,737,400.00 | 9,730,405.00 | 6,995.0 | 99.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2340000.00 | 2340000.00 | 0.0 | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1500000.00 | 1433836.00 | 66,164.0 | 95.6 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 186,045,100.00 | 185,258,207.04 | 786,893.0 | 99.6 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 00.00 | 00.00 | 0.0 | |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 173,045,100.00 | 173,045,100.00 | 0.0 | 100.0 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 13,360,000.00 | 13,000,000.00 | 360,000.0 | 97.3 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,360,000.00 | 13,000,000.00 | 360,000.0 | 97.3 |

*Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020.04.14-ны өдрийн 32 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчдад орон сууц, хашаа байшин худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх" журмын шаардлага хангасан албан хаагчдад аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 5000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгожээ.

Үүнээс Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 1 ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэж, 5000.0 мянган төгрөгийг орон сууцны дэмжлэг болгон өгсөн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 137 мэдээлэл, хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байгаа бөгөөд 5,6,8 дугаар сарuудад 29195.0 мянган төгрөгийн орлогын 4 гүйлгээ, 2,5,6,9,10 дугаар сарууддад 79004.6 мянган төгрөгийн 8 гүйлгээ, нийт 108199.6 мянган төгрөгийн 12 гүйлгээг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;"- д заасныг зөрчиж байгаа тул зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

*Хүснэгт 3: Шилэн дансны мэдээлэл*

| дд | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаандаа байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Хугацаа нь болоогүй мэдээлэл | Байршуулаагүй |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | 0 | 2 | 0 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 84 | 0 | | 12 |
| | **Нийт** | **27** | **151** | **137** | **0** | **2** | **12** |

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 325.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг 2020.03.24-ны өдөр төлж барагдуулсан байна.

*Хүснэгт 4:* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 325.0 | 1 | 325.0 | - | - | - |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | - |
| Зөвлөмж | | | | | - | - | - |
| Нийт дүн | 1 | 325.0 | 1 | 325.0 | - | - | - |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Тайлант онд аудитаар нийт 6602.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1973.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2800.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж, мөн санхүүгийн тайланд 1829.0 мянган төгрөгийн 1 залруулга хийсэн.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. БМ-ын тодруулга тайланд Үнэ төлбөргүй авсан 1829,0 мянган төгрөгийн бараа материалыг худалдаж авсан бараа материалаар ангилж, буруу бүртгэсэн.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 4773.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1973.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Ажилчдыг бүсийн тэмцээн уралдаанд оролцоход нь зориулж бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 1,680,000 төгрөгөөр биеийн тамирын хувцас хийлгэж төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.5.5 дахь заалтыг зөрчиж, "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1 Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдад олгосон биеийн тамирын хувцасны үнийг холбогдох ажилтнуудаар төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Аймгийн Засаг даргын 2020.02.17-ны өдрийн А/105 дугаар захирамжаар үндсэн цалингийн 50 хувиар урамшуулсныг 80 хувиар бодож, 293,937 төгрөгийг илүү олгосон байгаа нь аймгийн Засаг даргын 2020.02.17-ны өдрийн А/105 дугаар "Сум, агентлагийн 2019 оны үйл ажиллагааны дүнг баталж, шагнах тухай" захирамжийг зөрчиж, "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1. Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон урамшууллыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 2800.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Балансын данстай холбоотой асуудал*



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

1.1. *Илрүүлэлт:* Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-д заасан 5,6,8 дугаар саруудад 29195.0 мянган төгрөгийн орлогын 4 гүйлгээ, 2,5,6,9,10 дугаар саруудад 79004.6 мянган төгрөгийн 8 гүйлгээ, нийт 108199.6 мянган төгрөгийн 12 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

1.2. *Эрсдэл:* Холбогдох хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх, мэдээллийн ил тод байдал алдагдах.

1.3. *Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" -д заасны дагуу тухай бүр, үнэн зөв мэдээлж байх.

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

2. *Зардлын данстай холбоотой асуудал*

2.1. *Илрүүлэлт:* Тайлант хугацааны бараа материалын дансыг тулгахад кофе, цай, хоолны зардалд 2800.0 мянган төгрөгийг зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", бараа материалын хүнсний тайланд хоолыг орлого авч, зарлага гаргасан байгаа нь УСНББОУС-12-тай тус тус нийцэхгүй байна.

2.2. *Эрсдэл:* Холбогдох стандарт, хууль, тогтоомж, заавар журам зөрчигдөх.

2.3. *Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 6.4.1, УСНББОУС-д нийцүүлсэн гаргасан Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмын 4.15, 4.16-г мөрдөж ажиллах.

2.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/44/СТА- |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | **Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн алба** | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан 108199.6 мянган төгрөгийн 12 мэдээллийг мэдээлээгүй байна. | 0 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ц.Идэрмөнх, Л.Дуламсүрэн |
| 2 | Бүсийн тэмцээн уралдаанд зориулж 1680.0 мянган төгрөгөөр биеийн тамирын хувцас хийлгэж, зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна. | 1680.0 | Төлбөрийн акт тогтоох | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ц.Идэрмөнх, Л.Дуламсүрэн |
| 3 | Аймгийн Засаг даргын 2020.02.17-ны өдрийн А/105 дугаар захирамжаар үндсэн цалингийн 50 хувиар урамшуулсныг 80 хувиар бодож, 293,937 төгрөгийг илүү олгосон байна. | 293.9 | Төлбөрийн акт тогтоох | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ц.Идэрмөнх, Л.Дуламсүрэн |
| 4 | БМ-ын тодруулга тайланд Үнэ төлбөргүй авсан 1829,0 мянган төгрөгийн бараа материалыг худалдаж авсан бараа материалаар ангилж, буруу бүртгэсэн. | 1829.0 | Санхүүгийн тайланд залруулга хийх | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ц.Идэрмөнх, Л.Дуламсүрэн |
| 5 | Тайлант хугацааны бараа материалын дансыг тулгахад кофе, цай, хоолны зардалд 2800.0 мянган төгрөгийг зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, бараа материалын хүнсний тайланд | 2800.0 | Зөвлөмж өгөх | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ц.Идэрмөнх, Л.Дуламсүрэн |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хоолыг орлого авч, зарлага гаргасан байгаа нь УСНББОУС-12-тай тус тус нийцэхгүй байна. | | | | |
| **ДҮН** | | **6602.9** | | | |

Бэлтгэсэн:

АУДИТОР Б.НАРАНГЭРЭЛ
Огноо: 2021.02.03

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.03

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.03

641714354
ВЮА0067 9007423



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ